

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН БУЯНТ-УХАА ДАХЬ ГАЗРЫН 2018 ОНЫ АРВАН ХОЁРДУГААР САРД
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
/2018.11.26 - 2018.12.10/

2018 оны 12 дугаар сарын 11

Буянт-Ухаа

Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин	Биелэлт
1	2	3	4	5
1.	Дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах чиглэлээр	Хууль зүй, дотоод хэргийн сайдтай 2018 онд байгуулсан Байгууллагын даргын үр дүнгийн гэрээнд туссан тус газартай холбоотой заалтын биелэлт гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх.	Арга хэмжээний биелэлтийг үнэн зөв гаргаж Боомт, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	Хууль зүй, дотоод хэргийн сайдтай 2018 онд байгуулсан Байгууллагын даргын үр дүнгийн гэрээнд туссан тус газартай холбоотой манлайллын зорилтын 15 заалт, тусгай арга хэмжээний 1 заалтын биелэлт гаргаж 2018.12.10-ны өдөр БОНХ-т хүргүүлсэн.
2.		Буянт-Ухаа дахь газрын даргын 2018 онд байгууллагын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх илтгэх хуудсыг нэгтгэн гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх ажлыг зохион байгуулах	Арга хэмжээний биелэлтийг үнэн зөв гаргаж Боомт, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	Гадаадын иргэн, харьяатын газрын даргатай 2018 онд байгуулсан Буянт-Ухаа дахь газрын даргын үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх илтгэх хуудсыг боловсруулж ДШДАХ-т 2018.12.11-ний өдөр хүргүүлсэн болно. Түүнчлэн Тамгын газарт хувийг хүргүүлэв.
3.		Газрын үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэж холбогдох нэгжид хугацаанд нь хүргүүлэх.	Тайлан, төлөвлөгөөний биелэлт, хийх ажлын төлөвлөгөөнд тусгах саналыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасан хугацаанд албан хаагчдаас авч, нэгтгэн Боомт, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	Захиргаа, Төв аймаг дахь төлөөлөл, боомтод ажиллаж буй 4 ээлжээс хийсэн ажлын тайлан, төлөвлөгөөний биелэлт, хийх ажлын төлөвлөгөөнд тусгах саналыг байгууллагын Хөдөлмө-рийн дотоод журамд заасан хугацаанд авч, нэгтгэн Боомт, орон нутгийн хэлтэст 2018.12.10-ны өдөр хүргүүлсэн.

1	2	3	4	5
4.		Байгууллагын инфографик мэдээнд тусгах статистик тоог гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх ажлыг зохион байгуулах.	Тоон мэдээг 2017 онтой харьцуулан гаргаж Боомт, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	Гадаадын иргэн, харьяатын газраас гаргадаг инфографик мэдээнд тусгах тус газрын 2018 оны 12 дугаар сарын статистик тоог 2017 оны мөн үетэй харьцуулан гаргаж Боомт, орон нутгийн хэлтэст 2018.12.10-ны өдөр хүргүүлэв. Мэдээгээр 2017.11.26-2017.12.10-ны өдрийн байдлаар тус газарт ирсэн бичиг 2 /харицтай 2/, явсан бичиг 6, ирсэн өргөдөл 0, гомдол 0 байна. Харин 2018.11.26-2018.12.10-ны өдрийн байдлаар тус газарт ирсэн бичиг 1 /хариутай 1/, явсан бичиг 6, ирсэн өргөдөл 0, гомдол 0.
5.		Байгууллагын даргын батлан гаргасан албан даалгаврын биелэлтийг гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх ажлыг зохион байгуулах.	Албан даалгаврын биелэлтийг үнэн зөв гаргаж Боомт, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	Байгууллагын даргын батлан гаргасан 2017 оны 01, 03, 04, 05, 06, 07, 2018 оны 02, 04, 06, 08, 09, 10 дугаар албан даалгаврын биелэлтийг гаргаж Боомт, орон нутгийн хэлтэст 2018.12.06-ны өдөр хүргүүлэв.
6.		Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөө болон тус газраас сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах талаар 2018 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх.	Арга хэмжээний биелэлтийг үнэн зөв гаргаж Боомт, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	Засгийн газрын 2018 оны 258 дугаар “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөө болон тус газраас сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах талаар 2018 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг гаргаж 2018.12.12-ны өдөр БОНХ-т хүргүүлэв.
7.		Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөрийн биелэлтийг гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх	Биелэлтийг үнэн зөв гаргаж Боомт, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	Засгийн газрын 2010 оны 289 дүгээр тогтоолоор баталсан “Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр”-ийн тус газартай холбоотой заалтын биелэлтийг гаргаж Тамгын газарт 2018.12.17-ны өдөр хүргүүлсэн.

1	2	3	4	5
8.		Дүн шинжилгээ, дотоод аудитын хэлтсээс ирүүлсэн 01 дүгээр зөвлөмжийн тус газартай холбоотой заалтын хэрэгжилтийг гаргаж хүргүүлэх	Арга хэмжээний биелэлтийг үнэн зөв гаргаж Дүн шинжилгээ, дотоод аудитын хэлтэст хүргүүлсэн байна.	Дүн шинжилгээ, дотоод аудитын хэлтсээс ирүүлсэн 01 дүгээр зөвлөмжийн тус газартай холбоотой 5, 9, 11, 16, 17, 18, 21, 22, 23, 25 дахь заалтын хэрэгжилтийг гаргаж 2018.12.12-ны өдөр ДШДАХ-т хүргүүлсэн болно.
9.		“Төрийн албаны удирдах ажилтны улсын зөвлөгөөн-2018”-өөс гарсан зөвлөмжийн дагуу тус газраас хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх ажлыг зохион байгуулах	Арга хэмжээний биелэлтийг үнэн зөв гаргаж Боомт, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	“Төрийн албаны удирдах ажилтны улсын зөвлөгөөн-2018”-өөс гарсан зөвлөмжийн дагуу ГИХГ-ын Буянт-Ухаа дахь газраас хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг гаргаж БОНТ-т 2018.12.11-ний өдөр хүргүүлсэн. Нийт 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд биелэлт 100 хувьтай гарсан.
10.		Гадаадын иргэн, харьяатын газрын Буянт-Ухаа дахь газрын хяналт шалгалтын 2018 оны төлөвлөгөөний биелэлтийг гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх ажлыг зохион байгуулах	Арга хэмжээний биелэлтийг үнэн зөв гаргаж Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн байна.	Гадаадын иргэн, харьяатын газрын Буянт-Ухаа дахь газрын хяналт шалгалтын 2018 оны төлөвлөгөөний биелэлтийг гаргаж Хяналт шалгалтын газарт 218.12.13-ны өдөр хүргүүлсэн. Төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт 14, төлөвлөгөөт бус 2 хяналт шалгалт зохион байгуулсан. Хяналт шалгалтаар давхардсан тоогоор нийт 23 орны 1076 гадаадын иргэн, 89 аж ахуйн нэгж, байгууллага, 30 сүм хийд, цуглааны газар хамрагдсан бөгөөд оршин суух үнэмлэхээ биедээ авч явуугүй 1 орны 3 иргэнийг нийт 300,000 төгрөг, хуульд заасан хугацаанд оршин суух зөвшөөрлөө аваагүй 1 аж ахуйн нэгжийг /1 орны 30 иргэн/ нийт 12,500,000 төгрөгөөр торгож, ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан 1 орны 3 иргэнийг тус улсаас албадан гаргасан байна. Хяналт шалгалт бүрийг эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу зохион байгуулсан бөгөөд дүнг тухай бүр холбогдох албан тушаалтанд илтгэх хуудсаар танилцуулж ажиллалаа.

1	2	3	4	5
				<p>Өнөөдрийн байдлаар Төв аймагт нийт 16 орны 280 гадаадын иргэн бүртгэлтэй байгаа ба www.immigration.gov.mn/map сайтад бүртгэгдсэн байнгын ажиллагаатай 12 аж ахуйн нэгжид хяналт тавин ажиллаж байна.</p>
11.	Виз, бүртгэлийн чиглэлээр	Гадаадын иргэнд виз олгох, визний шилжүүлэг хийх, бүртгэл, хасалтын үйлчилгээ үзүүлэх.	Төрийн үйлчилгээг гадаадын иргэнд түргэн шуурхай үзүүлсэн байна.	<p>Нийт 53 орны 176 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын визийг олгосон бөгөөд үүнээс визийн шилжүүлэг 4 байна. Үүнд, нэг удаагийн орох 144, хоёр удаагийн орох 2, олон удаагийн орох 7, нэг удаагийн гарах-орох 14, хоёр удаагийн гарах-орох 1, олон удаагийн гарах-орох 4, дамжин өнгөрөх 0, түр ирэгчийн бүртгэл 22, хасалт 26, оршин суух зөвшөөрлийн хасалт 55 байна.</p> <p>Визийн хуудас 2 ширхэгийг тус газрын албан хаагч хүчингүй болгож, шинээр виз олгосон ба оршин суух зөвшөөрөлд хасалт хийгдээд олон удаагийн виз хүчингүй болгосон нийт 2 орны 2 иргэн оршин суух зөвшөөрөл огохолдоо олон удаагийн визийг хэвээр үлдээсэн байсныг хүчингүй болгосон.</p>
12.		Монгол Улсын визгүй, хориг арга хэмжээ авагдсан гадаадын иргэнийг буцаах арга хэмжээ авч ажиллах.	Гадаадын иргэний мэдээллийг "ISM" систем дээр шалгаж визгүй, хориг арга хэмжээтэй гадаадын иргэнийг хил нэвтрүүлэлгүй буцаасан байна.	<p>Монгол Улсад ирсэн зорилгоо тодорхойлж чадаагүй нийт 2 орны 2 гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр оруулаагүй буцаасан байна.</p> <p>Харин гарах визгүй, аж ахуйн нэгжийн албан бичиггүй зэрэг үндэслэлээр нийт 3 орны нийт 4 гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр гаргаагүй болно.</p> <p>Шүүх, прокурор, ШШГЕГ-ын хүсэлтийн дагуу Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн байхгүй байна.</p>

1	2	3	4	5
13.	Хяналт шалгалтын чиглэлээр	Төв аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа ААН-д бүртгэлээр хяналт тавьж, бүртгэлийн дагуу хяналт шалгалт хийх	Удирдамж батлуулан хяналт шалгалтыг зохион байгуулж, дүнг Буянт-Ухаа дахь газрын даргад танилцуулсан байна.	Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2018.11.20-ны өдөр баталсан УБ-02/2018-010 тоот удирдамжийн дагуу 2018.12.05-ны өдөр Төв аймгийн Зуунмод сумын 1-р багт оршин суух 1 орны 1 гадаадын амьдралын түвшинг тогтоохоор хяналт шалгалт хийж улсын байцаагчийн дүгнэлт бичин төвд хүргүүлсэн.
14.		Зөрчлийн тухай хуулийн дагуу ГИЭЗБТХууль зөрчсөн гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын зөрчлийг арилгаж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллах.	Зөрчил гаргасан гадаадын иргэн, ААН, байгууллагын зөрчлийг шийдвэрлэж, зөвлөгөө мэдээлэл өгсөн байна.	Бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн, визийн хугацаа хэтрүүлсэн, оршин суух журам зөрчсөн зэрэг үндэслэлээр 7 гадаадын иргэнд 830,000 төгрөг, 1 аж ахуйн нэгжид /хамрагдсан гадаадын иргэн 1/ 80,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилган, зөвлөгөө мэдээлэл өгөв.
15.		Хууль тогтоомж зөрчсөн гадаадын иргэнийг илрүүлсэн тохиолдолд Монгол Улсаас албадан гаргах үйл ажиллагааг зохион байгуулах.	Холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч, мэдээллийн нэгдсэн санд бүртгэл хийсэн байна.	Ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан 1 орны 1 гадаадын иргэнийг тус улсаас албадан гаргасан бөгөөд мэдээг мэдээллийн санд оруулсан. Түүнчлэн төвөөс нийт 3 орны 3 гадаадын иргэнийг албадан гаргаж буй үйл ажиллагаанд тус газрын албан хаагчид оролцож, тодорхойлолт үйлдэв.
16.		Визгүй зорчдог болон хоригт багтсан орны иргэдэд хил дээр тавих хяналтыг сайжруулж ажиллах.	Хил дээр тавих хяналт сайжирсан байна.	Монгол улсад визгүй зорчигч болон хоригт багтсан гадаадын иргэн, хөдөлмөр эрхлэх магадлалтай 3 орны 13 гадаадын иргэнтэй ярилцлага хийж бичиг баримтыг хуулбарлан хилээр гарсан байдалд хяналт тавьж бүртгэл хөтөлсөн болно. Иргэд харилцан зорчих нөхцөлийн талаар байгуулсан Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсад зорчин ирж буй 1 орны 2 гадаадын иргэнийг угтан авч буй Монгол Улсын иргэнээр баталгааны анкет бөглүүлэн хил нэвтрүүлж, уг гадаадын иргэний гарах хөдөлгөөнд хяналт тавин ажиллаж байна.

1	2	3	4	5
17.	Хүний нөөц, сургалтын чиглэлээр	Төрийн албаны зөвлөлийн цахим санд албан хаагчдын мэдээллийг шивж оруулан баяжилт хийх	Албан хаагчдын мэдээллийг нэг бүрчлэн шивж оруулсан байна.	Тус газрын албан хаагчдын мэдээлэл болох Буянт-Ухаа дахь газрын даргатай 2018 онд байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэсэн үнэлгээ, шагналын талаарх мэдээллийн Төрийн албаны зөвлөлийн цахим санд 2018.12.17-ны өдөр оруулав.
18.		Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгуулах санал боловсруулж холбогдох нэгжид хүргүүлэх ажлыг зохион байгуулах.	Төрийн үйлчилгээний албан хаагчдын хийсэн ажлыг нэгтгэн гаргаж ур чадварын нэмэгдэл олгуулах саналыг Тамгын газарт хүргүүлсэн байна.	Тус газрын 4 төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгуулах саналыг боловсруулж төвд хүргүүлсэн бөгөөд байгууллагын даргын тушаалын дагуу 3 албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг олгосон.
19.		Албан хаагчдын 2018 онд тус газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээ, төрийн үйлчилгээний албан хаагчдын хөдөлмөрийн гэрээний биелэлтийг дүгнэх ажлыг зохион байгуулж дүнг холбогдох нэгжид хүргүүлэх	Хийж гүцэтгэсэн ажлыг тус газрын дарга үнэн зөв дүгнэж дүнг Тамгын газар, Дүн шинжилгээ, дотоод аудитын хэлтэст тус тус хүргүүлсэн байна.	Буянт-Ухаа дахь газрын даргатай 2018 онд байгуулсан тус газрын төрийн захиргааны албан хаагчдын үр дүнгийн гэрээний биелэлт, төрийн үйлчилгээний албан хаагчдын Хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу 2018 онд хийж гүйцэтгэсэн ажлыг тус тус дүгнэж үнэлгээг Тамгын газарт 2018.12.18-ны өдөр илтгэх хуудсаар хүргүүлсэн. Энэ онд “А” үнэлгээ авсан 0 албан хаагч, “В” үнэлгээ авсан 11 албан хаагч, “С” үнэлгээ авсан 16 албан хаагч байна.
20.		“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгдүгээр шатны төлөвлөгөө”-ний Иргэдийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг сурталчлах ажлыг цагдаагийн	Албан хаагчдын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын талаарх мэдлэг дээшилсэн байна.	Тус газраас 2018.12.05-ны өдөр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх сургалт зохион байгуулж тус газрын 14 албан хаагч хамрагдан мэдлэгээ дээшлүүлэв. Сургалтад Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтсийн 1 албан хаагч хичээл оров. Тус сургалтаар албан хаагчид хар тамхи, мансууруулах бодисын ойлголт, төрөл зүйл, гадаад нөхцөл байдал, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар сурч мэдлэгээ дээшлүүлэв.

1	2	3	4	5
		байгууллага болон хууль хяналтын байгууллагатай хамтран зохион байгуулах		
21.		Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулах	Албан хаагчдын хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдлэг дээшилсэн байна.	Тус газраас 2018.12.05-ны өдөр хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулж Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтсийн 1 албан хаагч мэдээлэл хийв. Тус сургалтаар албан хаагчид хүн худалдаалах гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар сурч мэдлээ.
22.		Мэдээллийн аюулгүй байдлын эсрэг хийж байгаа гэмт халдлагын төрөл, хийгдэх болсон шалтгаан, түүнээс урьдчилан сэргийлэх аргын талаарх сургалтыг зохион байгуулах.	Аливаа мэдээлэл гэмт халдлагад өртөгдөхөөс урьдчилан сэргийлэгдсэн байна.	Мэдээллийг технологийн хэлтсийн сүлжээний ерөнхий инженер 2018.12.05-ны өдөр мэдээллийн аюулгүй байдлын эсрэг хийж байгаа гэмт халдлагын төрөл, хийгдэх болсон шалтгаан, түүнээс урьдчилан сэргийлэх аргын талаар сургалт зохион байгуулж тус газрын 14 албан хаагчдад мэдээлэл хийв.
23.		Тус газрын сургалтын төлөвлөгөөний биелэлтийг гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх ажлыг зохион байгуулах	Арга хэмжээний биелэлтийг үнэн зөв гаргаж Боомт, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	Гадаадын иргэн, харьяатын газрын Буянт-Ухаа дахь газраас 2018 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөний биелэлтийг гаргаж Тамгын газар болон БОНХ-т 2018.12.11-ний өдөр хүргүүлсэн. Тус төлөвлөгөөний дагуу нийт 18 төрлийн сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд биелэлт 100 хувьтай гарлаа.
24.		Тус газрын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх ажлыг зохион байгуулах	Арга хэмжээний биелэлтийг үнэн зөв гаргаж Боомт, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	ГИХГ-ын Буянт-Ухаа дахь газрын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2018 оны төлөвлөгөөний биелэлтийг гаргаж 2018.12.13-ны өдөр Тамгын газар болон БОНХ-т хүргүүлсэн. Нийт 19 төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд биелэлт 100 хувьтай гарлаа.

1	2	3	4	5
25.		<p>Үйлчлүүлэгчдээс албан хаагчид иргэдтэй хэрхэн харьцдаг, түргэн шуурхай чирэгдэл учруулахгүй үйлчилж буй талаар болон ёс зүйн холбогдолтой асуудлаар авсан судалгааг нэгтгэж холбогдох албан тушаалтанд танилцуулах.</p>	<p>Судалгааг нэгтгэн, газрын даргад танилцуулсан байна.</p>	<p>Тус газрын Ёс зүйн хороо нь үйлчлүүлэгчдээс албан хаагчид иргэдтэй хэрхэн харьцдаг, түргэн шуурхай чирэгдэл учруулахгүй үйлчилж буй талаар болон ёс зүйн холбогдолтой асуудлаар судалгаа авах ажлыг 2018.11.20-26-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд уг судалгааг нэгтгэн газрын даргад мөн сарын 27-ны өдөр илтгэх хуудсаар танилцуулсан. Судалгаанд нийт 8 орны 30 гаруй гадаадын иргэн хамрагдсан бөгөөд албан хаагчдын харилцааны ёс зүйн талаар санал, хүсэлт ирээгүй ба үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж байгаад сэтгэл ханамж дүүрэн байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.</p>
26.		<p>Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, өр авлагагүй ажиллах.</p>	<p>Төсөв санхүүгийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлэн ажилласан байна.</p>	<p>Батлагдсан төсөв болох өссөн дүнгээр 548,495,500 төгрөгийн санхүүжилт орсноор цалин хөлсөнд 302,349,745 төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэл 41,023,423 төгрөг, ХУД-т цалин хөлснөөс суутгасан ашгийн татварт 26,359,392 төгрөг, хангамж, бараа материалын зардалд 43,017,238 төгрөг зарцуулж өглөг авлага үүсгээгүй ажиллалаа.</p>
27.	<p>Санхүү, хангамжийн чиглэлээр</p>	<p>Төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг үнэн зөв гарган тогтоосон хугацаанд тайлагнах.</p>	<p>НД-ын шимтгэлийн тайланг дараа сарын 5, төсвийн гүйцэтгэлийн тайланг дараа сарын 2-ны өдрийн дотор гаргаж төсөв санхүүгийн үр ашигтай тогтолцоо бүрдсэн байна.</p>	<p>Төсвийн гүйцэтгэлийн мэдээг 2018.12.02-ны дотор гарган ХУД-ийн төрийн сангаар баталгаажуулан ГИХГ-ын Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн. Мэдээгээр 510,405,100 төгрөгийн урсгал санхүүжилт орсоноос нийт зарлага 451,716,296 төгрөгийн ажил үйлчилгээ явуулсан. Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг гарган 2018.12.05-ны дотор Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэн 75,944,146 төгрөгөөр тооцоо нийлэв.</p>
28.		<p>Үнэт цаасны тооцоо, авто машин ашиглалтын болон шатах тослох материалын тооцоог хугацаанд нь гаргаж, бүртгэл хөтлөн ажиллах.</p>	<p>Бүртгэл тооцоо хугацаандаа чанартай хийгдсэн байна.</p>	<p>Албан хаагчдад шийтгэлийн хуудас 49, визийн хуудас 300 ширхэгийг шаардах хуудасны дагуу олгосон. Түүнчлэн авто машины ашиглалт болон шатах тослох материалын тооцоог жолооч дэвтэрт бичилтийг хийн бүртгэл хөтлөв.</p>

1	2	3	4	5
29.		Төсвийн хүрээнд худалдан авалт хийх, албан хаагчдын ажиллах нөхцлөөр хангаж ажиллах.	Шаардлагатай бараа материалын худалдан авалт хийж шаардах хуудасны дагуу бараа материалыг тухай бүр нь гаргаж өгсөн байна.	Хангамж, бараа материалын зардалд өссөн дүнгээр 43,017,238 төгрөгийн худалдан авалт хийж, албан хаагчдыг шаардлагатай бараа материалаар хангаж ажилласан.
30.		Албан хэрэгцээнд ашиглаж буй суурин утас, шуудангийн болон боомтод байрлах албан хаагчдын ажлын байрны түрээсийн төлбөр тооцоог нэхэмжлэхийн дагуу тухай бүр шийдвэрлэх.	Нэхэмжлэхийн дагуу тухайн байгууллагын холбогдох дансруу шилжүүлэн өглөг авлагагүй ажиллана.	Албан хэрэгцээнд ашиглаж байгаа суурин утас болон интернетийн төлбөрт 3,509,496 төгрөг, байрны түрээс 26,632,250 төгрөг харилцагч байгууллагын нэхэмжлэхийн дагуу холбогдох данс руу шилжүүлсэн болно.
31.		Татварын улсын тэмдэгтийн хураамж, хүү, торгуулийн тайланг гаргаж тооцоо нийлэх.	Хяналтын улсын байцаагч нараас тайланг авч тулган, сар бүрийн 5-ны дотор төвд хүргүүлсэн байх.	Хүү торгууль өссөн дүнгээр 93,010,000 төгрөгийг Төв аймгийн төрийн санд, визийн тэмдэгтийн хураамж өссөн дүнгээр 433,420,510 төгрөг, визийн хуудас өссөн дүнгээр 32,701,708 төгрөгөөр тайлан нэгтгэн хяналтын улсын байцаагч нартай тооцоо нийлэн Гадаадын иргэн, харьяатын газрын Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн.
32.		Бараа материалын тайлан, кассын тайланг тухай бүр гаргах.	Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн ажилласан байна.	Бараа материалын болон шатахууны тайланг гаргахдаа Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн гаргасан ба хянуулж баталгаажуулсан. Түлш шатах тослох материалын тайлан өссөн дүнгээр 30,980,100 төгрөгний зарцуулалт гаргаж тайлагнасан.
33.		Газрын албан хаагчдын нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын дэвтэрт холбогдох бичилтийг хийх.	Албан хаагчдын НДД, ЭМД-ын дэвтэрт бичилт хийж нийгмийн даатгалын байцаагчаар НДД-ийг баталгаажуулсан байна.	Тус газрын нийт 28 албан хаагч, хүүхэд асрах чөлөөтэй 2 албан хаагчийн нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын дэвтэрт холбогдох бичилтийг хийж Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээр баталгаажуулав.

1	2	3	4	5
34.		Газрын 2018 оны үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг зохион байгуулах	Тооллогыг зохион байгуулсан байна.	Буянт-Ухаа дахь газрын даргын 2018.12.10-ны өдрийн А/24 дүгээр “Эд хөрөнгийн тооллого явуулах тухай”тушаалын дагуу 7 хүний бүрэлдэхүүнтэй тооллогын комисс 2018.12.11-ээс 15-ны өдрүүдэд тооллогыг зохион байгуулж дүнг тус газрын даргад 20-ны өдөр танилцуулахаар ажиллаж байна.
35.	Өргөдөл, гомдлын чиглэлээр	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас өргөдөл, гомдол гаргах бүрт бүртгэл хөтлөн, холбогдох албан хаагчид хүргүүлж, хуульд заасан хугацаанд шийдвэрлүүлэх.	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан хаагчаас гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч, хуульд заасан хугацаанд шийдвэрлүүлсэн байна.	Буянт-Ухаа дахь газарт ирсэн өргөдөл, гомдлыг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэж, уг өргөдөл, гомдолд Бүртгэл-хяналтын карт хөтөлж, газрын даргад танилцуулан шийдвэрлүүлж, хариуг хүргүүлэн ажилладаг болно. Тус газарт энэ сард иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан хаагчаас ирсэн өргөдөл, гомдол байхгүй болно.
36.	Бичиг хэрэг, архивын үйл ажиллагааны чиглэлээр	Газарт ирсэн, явсан албан бичгийн бүртгэл хөтөлж, хариутай албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах.	Ирсэн, явсан бичгийн бүртгэлийг хөтөлжсөн хариутай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна.	Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу тус газарт ирсэн нийт 1 албан бичгийг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэж, Бүртгэл-хяналтын карт хөтлөн, газрын даргад танилцуулан цохолт хийлгэж, холбогдох албан хаагчид шилжүүлэн хариутай 1 албан бичгийн шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин ажиллав. Хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн талаар Бүртгэл-хяналтын картад тэмдэглэв. Түүнчлэн тус газраас 6 албан бичиг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэв.
37.		Тус газарт ирсэн, явсан албан бичиг, тус газрын даргын баталсан тушаалыг сканердаж цахим архив үүсгэх.	Ирсэн, явсан албан бичиг, тус газрын даргын баталсан тушаалыг сканердаж цахим архив үүсгэсэн байна.	Тус газрын цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд газрын даргын баталсан үндсэн үйл ажиллагаатай холбоотой 2 тушаал, тус газарт ирсэн 1, явсан 6 албан бичиг, энэ сарын төлөвлөгөө, түүний биелэлт, тайланг сканердаж цахим хэлбэрт шилжүүлэв.

1	2	3	4	5
38.		Архивын өрөөний чийг, дулааныг хэмжиж бүртгэл хөтлөх.	Хэмжилтийг өдөр бүр хийж, бүртгэл хөтөлсөн байна.	Тус газрын архивын өрөөний чийг, дулааныг 2018.10.26-2018.11.25-ны өдрүүдэд өдөр бүр хэмжиж дэвтэрх бичилт хийн ажиллав. Дулаан 20-23 С, чийг 30-33 HR байна.
39.		Болзошгүй нөхцөлд ашиглах үүднээс галын хорыг тус газрын архивын баримт хадгалж буй өрөөнд байрлуулах ажлыг зохион байгуулах	Болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэгдсэн байна.	Болзошгүй нөхцөлд ашиглах үүднээс галын хор шинээр 5 ширхэгийг 182,500 төгрөгөөр худалдан авч тус газрын захиргаа, архивын баримт хадгалж буй өрөө, Буянт-Ухаа боомт дахь тус газрын албан хаагчдын үйл ажиллагаа явуулдаг байранд байрлуулсан.
40.	Мэдээллийн технологийн чиглэлээр	Сүлжээний тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллах.	Ирсэн дуудлагын дагуу засвар үйлчилгээг хийж хэвийн ажиллагаанд оруулсан байна.	Дотоод сүлжээний 5, техник хэрэгслийн 3, нийт 8 дуудлага хүлээн авч засварлан хэвийн ажиллагаанд оруулсан. Үүнд: “Чингис хаан” олон улсын нисэх буудлын тус газрын харьяа явагчийн өрөөний дотоод сүлжээтэй компьютерийн “ISM” програм 2018.11.28-ны өдөр гацсан тул 10.204.32.21 IP хаягтай серверийг 10.204.32.22 IP хаягаар сольж “ISM” програмыг хэвийн ажиллагаанд оруулж, паспортын хуурмаглал шалгадаг компьютер ажиллахгүй байсныг 2018.11.30-ны өдөр засч, 2018.12.10-ны зорчигчийн мэдээлэл шалгадаг “APIS” програм ажиллахгүй байсныг хэвийн ажиллагаанд оруулсан ба мөн өдөр “ISM” програм удаашралтай гацаж байсны улмаас хилийн 0218-р ангийн сүлжээний инженерүүдтэй хамтран ажиллаж хурд удааширч, гацаж байгаа шалтгааныг олж тогтоолоо. Түүнчлэн принтерийн тохиргоо алдагдсан 3 дуудлага хүлээн авч тухай бүрт хэвийн ажиллагаанд оруулсан ба “ACER” маркийн нөүтбүүкийг форматлан, ашиглагдах програмуудыг суулган хэвийн ажиллагаанд оруулсан.

1	2	3	4	5
41.	Олон нийттэй харилцах чиглэлээр	Төсвийн зарцуулалтын талаар Shilendans.gov.mn сайтад мэдээллийг тухай бүр оруулж, иргэд хүссэн мэдээллээ авах боломжийг бүрдүүлэх.	Шилэн дансны хуулийн хэрэгжилт болон төсвийн ил тод байдлыг ханган ажиллаж, мэдээг үнэн зөв оруулсан байна.	Төсвийн зарцуулалтын талаар Shilendans.gov.mn сайтад мэдээллийг шивж оруулсан. Үүнд, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл зэрэг болно.
42.		Тус газрын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг бэлтгэн байгууллагын цахим хуудсанд байршуулах ажлыг зохион байгуулах.	Тус газрын сарын төлөвлөгөө, биелэлт, тайлан, өргөдөл, гомдлын мэдээг байгууллагын цахим хуудсанд байршуулсан байна.	Тус газрын арван хоёрдугаар сарын төлөвлөгөөний биелэлт, тайлан, өргөдөл, гомдлын мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулан гаргаж байгууллагын цахим хуудсанд байршуулж олон нийтийг мэдээллээр ханган ажиллалаа.
43.	Цагдаагийн байгууллага, гадаадын иргэн, харьяатын байгууллагын хамтран ажиллах журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд	Цагдаагийн байгууллага, гадаадын иргэн, харьяатын байгууллагын хамтран ажиллах журмын биелэлтийг гаргах	Арга хэмжээний биелэлтийг үнэн зөв гаргаж Боомт, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	Цагдаагийн байгууллага, гадаадын иргэн, харьяатын байгууллагын хамтран ажиллах журмын биелэлтийг гаргаж 2018 оны 12 дугаар сарын 11-ний өдөр тус газрын даргад танилцуулсан.

1	2	3	4	5
44.		Зөрчлийн тухай хуульд заагдсан зөрчил гаргасан гадаадын иргэний зөрчлийн талаарх мэдээлэл, судалгааг гаргаж хүргүүлэх	Холбогдох сүлжээнээс шүүлт хийж, үнэн, зөв мэдээллээр хангасан байна.	Зөрчлийн тухай хуульд заагдсан зөрчил гаргасан гадаадын иргэний зөрчлийн талаарх мэдээллийг аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэст, хүү торгууль 93,010,000 төгрөгийг Төв аймгийн төрийн санд төвлөрүүлж ажилласан талаар, зөрчил гаргасан гадаадын иргэний талаарх мэдээ болон гэмт хэрэгт холбогдсон гадаадын иргэн байхгүй талаарх мэдээг тус аймгийн Цагдаагийн газарт 2018.12.04-ний өдөр тус тус хүргүүлсэн болно.
45.		Төв аймгийн нутаг дэвсгэрт оршин сууж буй гадаадын иргэний мэдээллийг сүлжээнээс шүүж цагдаагийн хэсгийн байцаагч нарт хүргүүлэх	Холбогдох сүлжээнээс шүүлт хийж, үнэн, зөв мэдээллээр хангасан байна.	Төв аймгийн нутаг дэвсгэрт оршин сууж буй гадаадын иргэний мэдээллийг “ISM” сүлжээнээс шүүж тус аймгийн Цагдаагийн газарт 2018.12.04-ний өдөр хүргүүлж мэдээллээр ханган ажиллалаа. Мэдээгээр тус аймгийн 27 сум, 97 багт нийт 16 орны 280 гадаадын иргэн бүртгэлтэй байна.
46.		Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу захиргааны шийтгэл ногдуулсан болон албадан гаргаж, орохыг хориглосон гадаадын иргэний талаарх мэдээлэл	Холбогдох сүлжээнээс шүүлт хийж, үнэн, зөв мэдээллээр хангасан байна.	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу захиргааны шийтгэл ногдуулсан болон албадан гаргаж, орохыг хориглосон гадаадын иргэний талаарх мэдээллийг гаргаж 2018.12.04-ний өдөр Цагдаагийн газарт хүргүүлж мэдээллээр ханган ажиллалаа.